

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны .. дугаар  
сарын ..-ны өдөр

Улаанбаатар  
хот

## ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрээс гаралтай генетик нөөц болон түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг судлах, бүртгэх, хадгалж хамгаалах, ашиглах, үр шимийг харилцан хүртэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл. Генетик нөөцийн тухай хууль тогтоомж**

2.1. Генетик нөөцийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ойн тухай хууль, Байгалийн ургамлын тухай хууль, Амьтны тухай хууль, Хувиргасан амьд организмын тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Иргэний хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.

**3 дугаар зүйл. Хуулийн хамрах хүрээ**

3.1. Энэ хууль нь ургамал, амьтан, бичил биетнээс гаралтай генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгт хамааралтай харилцаанд үйлчилнэ.

3.2. Энэ хууль нь хүний генетик нөөц болон Малын генетик нөөцийн тухай хуулийн 3.1-д заасан харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

**4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. "амьтан" гэж Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.4-т заасныг;

4.1.2. "биологийн нөөц" гэж генетик нөөц болон бодит эсхүл боломжит үнэ цэнэ бүхий экосистемийн амьд бүрэлдэхүүн хэсгийг;

4.1.3. "биосоёлын протокол" гэж иргэд орон нутгийнхаа генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг тодорхойлж, түүнийг бусад этгээдэд ашиглуулах нөхцөлийг хэлэлцэн тохирсон баримт бичгийг;

4.1.4. "биотехнологи" гэж Биологийн олон янз байдлын тухай конвенцийн 2 дугаар зүйлд заасанчлан биологийн систем, амьд биес, тэдгээрээс гаралтай үүсмэлийг ашиглан тодорхой зориулалт бүхий бүтээгдэхүүн, эсхүл арга ажиллагаа бий болгох аливаа технологийг;

4.1.5. “биохайгуул” гэж биологийн олон янз байдлын генетик нөөцийг арилжааны зорилгоор хайх, судлах үйл явцыг;

4.1.6. “бичил биетэн” гэж энгийн нүдэнд үл үзэгдэх нэг ба олон эст амьд бие, вирусыг;

4.1.7. “генетик материал” гэж ургамал, амьтан, бичил биетний болон бусад гаралтай удамшлын функциональ нэгж агуулсан аливаа материалыг;

4.1.8. “генетик нөөц” гэж бодит, эсхүл боломжит үнэ цэнэ бүхий генетик материал, үүсмэлийг;

4.1.9. “генетик нөөц ашиглах” гэж генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг судалгааны болон арилжааны зорилгоор илрүүлэх, цуглуулах, судлах, боловсруулах, бүтээгдэхүүн бий болгох үйл ажиллагааг;

4.1.10. “генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг” гэж үеэс үед өвлөгдөн уламжлагдаж ирсэн, биологийн нөөцийн онцлог шинж чанар, түүнийг ашиглах арга ухаан, мэдлэг, ур чадварыг;

4.1.11. “генетик нөөцийн үндэсний сан” гэж амьд бие, эрхтэн, эд, эс, өсгөвөр, удамшлын материалын биет болон тоон мэдээллийн сан хөмрөгийг;

4.1.12. “олон улсын мэдээлэл солилцооны төв” гэж холбогдох олон улсын гэрээний хүрээнд гишүүн орнуудын дунд хэрэгждэг генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн ашиглалтын талаарх мэдээлэл солилцох тогтолцоог;

4.1.13. “ургамал” гэж Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.3-т заасныг;

4.1.14. “урьдчилсан зөвшөөрөл” гэж генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгээ ашиглуулж болох талаар эзэмшигчээс өгсөн албан ёсны зөвшөөрлийг;

4.1.15. “үр шимийн гэрээ” гэж генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах, тэдгээрийг ашигласнаас үүдэх үр шимийг харилцан хүртэх нөхцөлийг тодорхойлсон генетик нөөц эзэмшигч ба ашиглагчийн хооронд байгуулсан хэлцлийн баримт бичгийг;

4.1.16. “үүсмэл” гэж биологийн эсхүл генетик нөөцийн генийн илрэл, бодисын солилцооны дүнд үүсэх байгалийн биохимийн нэгдлийг.

## **5 дугаар зүйл. Хуулийн зарчим**

5.1. Төрөөс генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглахад дараахь зарчим баримтална:

5.1.1. генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг шинжлэх ухааны үндэслэлтэй зохистой ашиглах нөхцөлийг бүрдүүлэх;

5.1.2. генетик нөөцийг хамгаалах, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах шийдвэр, үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх;

5.1.3. генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашигласнаас үүдэх үр шимийг шударга, харилцан эрх тэгш хүртээх.

## **6 дугаар зүйл. Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн өмчлөл, эзэмшил**

6.1.Монгол Улсын нутаг дэвсгэрээс гаралтай генетик нөөц төрийн өмчлөлд байна.

6.2.Генетик нөөцтэй холбоотой тухайн уламжлалт мэдлэгийн эзэмшигчийг энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан журмын дагуу тогтоох боломжгүй тохиолдолд төр эзэмшигч байна.

6.3.Энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг судлах, биохайгуул хийх, ашиглах эрхийг хуулийн этгээдэд олгож болно.

6.4.Энэ хуульд заасан тусгай зөвшөөрөлгүйгээр генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг илрүүлэх, биохайгуул хийх, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэхгүй ашиглах, гадаадын иргэн, хуулийн этгээдэд дамжуулах, худалдах, үр шимийг харилцан хүртэхийг хориглоно.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

### **ГЕНЕТИК НӨӨЦ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ УЛАМЖЛАЛТ МЭДЛЭГТЭЙ ХОЛБОГДОХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ**

**7 дугаар зүйл. Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгтэй холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага**

7.1.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид “төрийн захиргааны төв байгууллага” гэх/ генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн харилцааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

7.1.2.энэ хуульд заасан урьдчилсан зөвшөөрөл, биосоёлын протокол, тусгай зөвшөөрөл, үр шимийн гэрээ, газарзүйн гарал үүслийн тодорхойлолт, материал дамжуулах гэрээний загварыг батлах;

7.1.3.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах тусгай зөвшөөрөл /цаашид “тусгай зөвшөөрөл “гэх/ олгох, цуцлах, тусгай зөвшөөрөл шаардах үйл ажиллагаа болон нөөцийн жагсаалт батлах;

7.1.4.генетик нөөцийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох;

7.1.5.энэ хуулийн 15.1-д заасан үр шимийн гэрээний хэрэгжилтийг хянаж шалгах, гэрээний биелэлт хангалтгүй гэж дүгнэвэл хүчингүй болгох;

7.1.6.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглан гарган авсан бүтээгдэхүүний үнэ, эрэлт, хэрэгцээ, хэтийн төлвийг судлах;

7.1.7.генетик нөөцийн тархац, ангилал зүйн судалгаа, нөөцийн үнэлгээг хийлгэх;

7.1.8.генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн судалгаа, тооллого зохион байгуулж бүртгэх;

7.1.8.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг хамгаалах, судлах, ашиглахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох этгээдээс мэдээлэл, тайлан гаргуулах;

7.1.9.биологийн судалгааны үр дүн, инноваци, арилжааны өмнөх болон дараа үеийн холбогдох мэдээллийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гаргуулах;

7.1.10.олон нийтэд генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн талаар мэдлэг олгох ажлыг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомжийг сурталчлах;

7.1.11.холбогдох олон улсын гэрээний үндэсний зохицуулагчийн үүргийг гүйцэтгэх, олон улсын мэдээлэл солилцооны төвтэй харилцах;

7.1.12.энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжийг хэлэлцэж, холбогдох шийдвэрийг гаргах;

7.1.13.хуульд заасан бусад бүрэн эрх.

7.2.Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн асуудалд оюуны өмчийн эрх үүссэн эсэхийг хянаж шалгах бөгөөд үүссэн тохиолдолд энэ талаар төрийн захиргааны төв байгууллагад мэдээлнэ.

7.3.Хүнс, хөдөө аж ахуй, эм зүй, шинжлэх ухаан, биотехнологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн салбарт хамаарах генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн талаарх ёс зүйн дүрмийг батална.

7.4.Аймаг, нийслэлийн байгаль орчны алба нь генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.4.1.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн талаарх хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан шийдвэрийн биелэлтийг өөрийн нутаг дэвсгэртээ зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

7.4.2.энэ хуулийн 9.3.2-т заасан бүртгэлийг үндэслэн генетик нөөцийн зүйлийн газарзүйн гарал үүслийн тодорхойлолтыг 14 хоногийн дотор олгох;

7.4.3.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг эзэмшигч, ашиглагчийн хооронд байгуулсан үр шимийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;

7.4.4.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэг болон био соёлын протоколыг бүртгэж, энэ хуулийн 9.3-т заасан мэдээллийн нэгдсэн санд 5 хоногийн дотор оруулна.

## **8 дугаар зүйл. Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн мэргэжлийн зөвлөл**

8.1.Төрийн захиргааны төв байгууллагын дэргэд мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бус Мэргэжлийн зөвлөл /цаашид “Мэргэжлийн зөвлөл” гэх/ ажиллана.

8.2.Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Мэргэжлийн зөвлөлийн дүрмийг баталж, бүрэлдэхүүнийг томилж, чөлөөлнө.

8.3.Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнд холбогдох салбарын эрдэмтэн судлаачид, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагын төлөөллийг оруулна.

8.4.Мэргэжлийн зөвлөл дараах чиг үүрэгтэй:

8.4.1.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн талаарх хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал, зөвлөмж гаргах;

8.4.2.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн талаарх биосоёлын протокол, энэ хуулийн 7.4-т заасан төрийн захиргааны төв байгууллагаас батлах салбарын ёс зүйн дүрмийн төсөлтэй танилцаж зөвлөмж гаргах;

8.4.3.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг арилжааны зорилгоор ашиглах, биохайгуул хийх хүсэлтийг хянаж дүгнэлт, зөвлөмж гаргах;

8.4.4.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн судалгааны ажлын үр дүнтэй танилцаж, дүгнэлт гаргах.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

### **ГЕНЕТИК НӨӨЦ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ УЛАМЖЛАЛТ МЭДЛЭГИЙГ БҮРТГЭХ, ХАДГАЛЖ ХАМГААЛАХ**

**9 дүгээр зүйл. Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан**

9.1.Төрийн захиргааны төв байгууллага нь генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан /цаашид “мэдээллийн нэгдсэн сан” гэх/-тай байна.

9.2.Мэдээллийн нэгдсэн сан нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 35 дугаар зүйлд заасан мэдээллийн сангийн бүрдэл хэсэг байна.

9.3.Мэдээллийн нэгдсэн сан нь дараах дэд сан, мэдээллээс бүрдэнэ:

9.3.1.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн мэдээллийн сан;

9.3.2.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн ашиглалтын цахим бүртгэл;

9.3.3.генетик нөөцийн үндэсний сангийн тоон өгөгдлийн сан;

9.3.4.холбогдох бусад мэдээлэл.

9.4.Мэдээллийн нэгдсэн сан нь олон улсын мэдээлэл солилцооны төв болон салбарын бусад мэдээллийн сантай уялдсан байна.

9.5.Энэ хуулийн 9.1-д заасан мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хөтлөх, ашиглах, хадгалах, хамгаалах журам болон мэдээллийн сангийн бүрдэл үзүүлэлтийн жагсаалт, бүртгэлийн маягтыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9.6.Иргэн, хуулийн этгээд өөрт хадгалагдаж байгаа генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн талаарх ном судар, эрдэм шинжилгээний бүтээл, гар бичмэл, аман мэдээлэл, эдгээртэй адилтгах бусад мэдээллийн цахим хуулбарыг мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлж, хадгалуулахаар хүргүүлж болно.

9.7.Энэ хуулийн 9.6-д заасан этгээд генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлээгүй тохиолдолд үр шимийг хүртэх эрх үүсэхгүй.

9.8.Генетик нөөцтэй холбоогүй уламжлалт мэдлэгийг бүртгэх, хадгалж, хамгаалах харилцааг Соёлын өвийг хамгаалах тухай хуулиар зохицуулна.

**10 дугаар зүйл. Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг хадгалж хамгаалах**

10.1.Генетик нөөц агуулсан биологийн нөөцийг уугуул амьдрах орчныг хадгалж тэтгэх болон гаршуулж тэжээх, нутагшуулах, сэргээн нутагшуулах,

тарималжуулах, ботаникийн цэцэрлэг, генетик нөөцийн үндэсний сан байгуулах замаар хамгаална.

10.2.Төрийн захиргааны төв байгууллага нь генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн эрэл хайгуул, судалгааг зохион байгуулж мэдээллийн нэгдсэн санд бүртгэж хамгаална.

10.3.Төрийн захиргааны төв байгууллага нь иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн уламжлалт мэдлэгт хамаарах энэ хуулийн 9.6-д заасан мэдээллийг нууцлалыг хадгална.

## **11 дүгээр зүйл. Генетик нөөцийн үндэсний сан**

11.1.Генетик нөөцийн үндэсний санд хамрагдах генетик материалын биет сан хөмрөг, түүний тоон өгөгдлийн санг тухайн чиглэлийн суурь судалгаа хийх үүрэг бүхий, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас итгэмжилсэн төрийн өмчийн их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага төрөлжүүлсэн байдлаар эрхэлнэ.

11.2.Энэ хуулийн 11.1-д заасан төрөлжсөн сан хөмрөг эрхэлж байгаа байгууллага нь өөрт хадгалагдаж байгаа холбогдох мэдээллээ 9.2.3-т заасан генетик нөөцийн үндэсний сангийн тоон өгөгдлийн санд хүргүүлнэ.

11.3.Генетик нөөцийн үндэсний сан байгуулах, сан хөмрөгийг баяжуулж бүртгэх, хадгалж хамгаалах, түгээх, солилцох журам, генетик нөөцийн үндэсний сангийн дүрмийг төрийн захиргааны төв байгууллага батална.

11.4.Генетик нөөцийн биет сан хөмрөгийн хадгалалтын болон тоон өгөгдлийн сангийн ерөнхий шаардлагын стандартыг төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулна.

11.5.Генетик материалын биет сан хөмрөгийг байгуулах, эрхлэх, хадгалах, хамгаалахтай холбоотой зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

### **ГЕНЕТИК НӨӨЦ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ УЛАМЖЛАЛТ МЭДЛЭГИЙГ АШИГЛАХ**

**12 дугаар зүйл. Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглахад тавих ерөнхий шаардлага**

12.1.Төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах тусгай зөвшөөрлийг дараах этгээдэд олгоно:

12.1.1.Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд;

12.1.2.энэ хуулийн 12.1.1-д заасан хуулийн этгээд нь гадаадын хөрөнгө оруулалттай тохиолдолд дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээ нь 51-ээс доошгүй хувь байна.

12.1.3.энэ хуулийн 12.1.1-д заасан хуулийн этгээдтэй хамтран ажиллах гэрээтэй гадаадын хуулийн этгээд.

12.2.Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах хүсэлт гаргагч /цаашид “хүсэлт гаргагч” гэх/ энэ хуулийн 14.1-д заасан мэдээллийг энэ хуулийн 9.3.2-т заасан ашиглалтын цахим бүртгэлд хүсэлтээ илгээж бүртгүүлнэ.

### **13 дугаар зүйл. Урьдчилсан зөвшөөрөл**

13.1.Генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах тохиолдолд хүсэлт гаргагч нь тухайн генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг эзэмшигчээс урьдчилсан зөвшөөрөл авна.

13.2.Генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг энэ хуулийн 6.2-т зааснаар төр эзэмшиж байгаа бол урьдчилсан зөвшөөрөл авахыг шаардахгүй.

13.3.Энэ хуулийн 13.2-т зааснаар урьдчилсан зөвшөөрөл аваагүй нь энэ хуулийн 9.3.2-т заасан ашиглалтын цахим бүртгэлд бүртгүүлэх үүргээс чөлөөлөхгүй.

13.4.Урьдчилсан зөвшөөрөл авахын өмнө хүсэлт гаргагч нь орон нутгийн иргэдийн биосоёлын протоколтой танилцаж, генетик нөөцтэй холбоотой тухайн уламжлалт мэдлэгийн үнэ цэнэ, үр шимийн талаар эзэмшигчид тайлбарлан таниулна.

13.5.Генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг эзэмшигчийг тодорхойлох, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах урьдчилсан зөвшөөрөл авах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

13.6.Генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг нь хоёр ба түүнээс олон засаг захиргааны нэгжид оршин суугаа иргэдэд хамаарах тохиолдолд төрийн захиргааны төв байгууллага холбогдох нутгийн захиргааны байгууллагатай зөвшилцөн энэ хуулийн 13.5-д заасан журмын дагуу эзэмшигчийг тогтооно.

### **14 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох**

14.1.Энэ хуулийн 12.1-д заасан шаардлагыг хангасан этгээд генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг судалгааны болон арилжааны зорилгоор ашиглах хүсэлтээ төрийн захиргааны төв байгууллагад гаргах бөгөөд түүнд дараах баримт бичгийг хавсаргана:

14.1.1.энэ хуулийн 15.1.2-т заасан мэдээлэл болон уламжлалт мэдлэгийн танилцуулга;

14.1.2.хуулийн этгээдийн гэрчилгээний хуулбар;

14.1.3.хуулийн этгээдийн танилцуулга;

14.1.4.гадаадын хуулийн этгээд бол хамтран ажиллах дотоодын хуулийн этгээдтэй хийсэн гэрээ;

14.1.5.ашиглалтын цахим бүртгэлд бүртгүүлсэн баримт;

14.1.6.хувийн эзэмшлийн уламжлалт мэдлэг ашиглах тохиолдолд энэ хуулийн 13.1-д заасан урьдчилсан зөвшөөрөл;

14.1.7.газарзүйн гарал үүслийн тодорхойлолт;

14.1.8.генетик нөөц, уламжлалт мэдлэгийг хадгалах, хамгаалах, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлэх арга хэмжээний танилцуулга.

14.2.Хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн тухай Монгол улсын олон улсын гэрээнд заасан ургамлыг хүнс, тэжээлийн зорилгоор ашиглах тохиолдолд тусгай зөвшөөрөл авах шаардлагагүй.

14.3.Улсын төсвийн хөрөнгөөр амьтан, ургамал, бичил биетний тархац, ангилал зүй, нөөцийн судалгаа хийхэд тусгай зөвшөөрөл шаардахгүй.

14.4.Энэ хуулийн 14.3-т заасан судалгааны ажил эхлэхээс өмнө холбогдох мэдээллийг энэ хуулийн 9.3.2-т заасан ашиглалтын цахим бүртгэлд бүртгүүлэх бөгөөд судалгааны ажлын үр дүнг улирал тутамд шинэчлэн энэ хуулийн 9.3.1-д заасан мэдээллийн санд тайлагнана.

14.5.Энэ хуулийн 14.2, 14.3-т зааснаар тусгай зөвшөөрөл аваагүй нь энэ хуулийн 9.3-т заасан мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх үүргээс чөлөөлөхгүй.

14.6.Төрийн захиргааны төв байгууллага Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрөл олгох тухай хүсэлт хүлээн авснаас хойш судалгааны зорилгоор ашиглах бол 14 хоног, арилжааны зорилгоор ашиглах бол 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг төрийн захиргааны төв байгууллагын эрх бүхий албан тушаалтан 30 хүртэл хоногоор сунгаж болно.

14.7.Ургамал, амьтны биологийн нөөц бэлтгэх зөвшөөрөлтэй холбоотой харилцааг Байгалийн ургамлын тухай, Ойн тухай, Амьтны тухай хуулиар тус тус зохицуулна.

14.8.Мэргэжлийн зөвлөл тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үр шимийн гэрээний хэрэгжилтийг хангалтгүй гэж дүгнэлт гаргасан нь тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл болно.

14.9.Энэ хуулийн 12.1.3-т заасан хамтран ажиллах гэрээг цуцалсан, эсхүл дуусгавар болгосон бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

14.10.Эрдэм шинжилгээ, судалгааны үр дүнг арилжааны зорилгоор ашиглах тохиолдолд дахин хүсэлт гаргаж тусгай зөвшөөрөл авна.

14.11.Энэ хуулийн 13.1, 13.4, 15.2, 19.1-д заасан шаардлагыг зөрчсөн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

14.12.Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг судалгааны болон арилжааны зорилгоор ашиглаж байгаа хуулийн этгээд Генетик нөөцийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ 180 хоногийн дотор төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

14.13.Энэ хуулийн 14.12-т заасан хугацаанд төрийн захиргааны төв байгууллагад хүсэлтээ гаргаагүй бол тусгай зөвшөөрөлгүйгээр генетик нөөц, түүнтэй холбоотой мэдлэгийг ашигласан гэж үзнэ.

14.14.Тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхийг хориглоно.

## **15 дугаар зүйл. Үр шимийн гэрээ**

15.1.Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь төрийн захиргааны төв байгууллага, эсхүл тухайн генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг эзэмшигчтэй үр шимийн гэрээ /цаашид “гэрээ” гэх/ байгуулах бөгөөд түүнд дараах нөхцөлийг тусгана:

15.1.1.гэрээний зорилго, хугацаа;

15.1.2.генетик нөөцийг ашиглах зорилго, зориулалт, ургамал, амьтан, бичил биетний шинжлэх ухааны нэр эсхүл бичил биетний эх үүсвэр, омгийн нэр,



өсгөврийн сангийн дугаар, судалгааны үр дүнд бий болох оюуны өмчийн эрхийн талаарх нөхцөл;

15.1.3.генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах зорилго, зориулалт, судалгааны үр дүнд бий болох оюуны өмчийн эрхийн талаарх нөхцөл;

15.1.4.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах нөхцөл;

15.1.5.материал дамжуулах гэрээ;

15.1.6.хадгалах, хамгаалах нөхцөл, төлөвлөгөө;

15.1.7.маргаан шийдвэрлэх зохицуулалт;

15.1.8.ашиглалтаас үүдэх үр шимийг генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэг эзэмшигчид хүртээх нөхцөл;

15.1.9.генетик нөөцтэй холбоотой хамтын эзэмшлийн уламжлалт мэдлэгийг ашиглах тохиолдолд энэ хуулийн 15.1.1- 15.1.8-д зааснаас гадна тухайн орон нутгийн иргэдийн биосоёлын протоколд заасан нөхцөл.

15.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үр шимийн гэрээний хуулбар хувийг төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлнэ.

15.3.Төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 15.1-д заасан гэрээний нууцлалыг хадгална.

## **16 дугаар зүйл. Генетик нөөцийг хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл**

16.1.Генетик нөөцийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд энэ хуулийн 16.2-т заасан журмын дагуу төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авна.

16.2.Генетик нөөцийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

16.3.Бичил биетнийг зөвхөн өсгөвөр хэлбэрээр Монгол Улсын хилээр нэвтрүүлнэ.

16.4.Генетик нөөцийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхдээ генетик нөөцийн биет, эсхүл сорьцын ижил хувийг генетик нөөцийн үндэсний санд хадгалуулна.

## **17 дугаар зүйл. Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашигласнаас үүдэх үр шим**

17.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Иргэний хуулийн 88.1-88.3-т заасны дагуу генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласнаас үүдэх үр шимийг эзэмшигчид хүртээнэ.

17.2.Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашигласнаас үүдэх үр шим нь мөнгөн ба мөнгөн бус хэлбэртэй байна.

17.3.Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашигласнаас үүдэх мөнгөн үр шим нь судалгаа, боловсруулалтын үр дүнд бий болсон бүтээгдэхүүний борлуулалтын орлого, тусгай зөвшөөрлийн хураамж, оюуны өмчийн эрхийн хамтын эзэмшил болон бусад хэлбэртэй байж болно.

17.4.Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашигласнаас үүдэх мөнгөн бус үр шим нь дараах хэлбэртэй байж болно:

17.4.1.хамтарсан судалгаа хийх;

17.4.2.бүтээгдэхүүн хамтран хөгжүүлэх;

- 17.4.3. чадавх бэхжүүлэх;
- 17.4.4. технологи дамжуулах, багаж тоног төхөөрөмж нийлүүлэх;
- 17.4.5. холбогдох олон улсын гэрээнд заасан бусад хэлбэр.

17.5. Энэ хуулийн 15.1-д заасан гэрээ байгуулагч талууд хоорондоо харилцан тохиролцож генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашигласнаас үүдэх үр шимийг мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр хүртэх талаар гэрээнд заана.

## **18 дугаар зүйл. Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласны төлбөр, түүнийг төлөх**

18.1. Амьтан, ургамлын нөөц ашигласны төлбөрийг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар зохицуулна.

18.2. Энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан тусгай зөвшөөрлийн төлбөр, 16 дугаар зүйлийн 16.3-т заасан бичил биетнийг гадаад улсад гаргахад өсгөврийн тоогоор Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан төлбөр төлнө.

18.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь генетик нөөц ашиглан гаргаж авсан бүтээгдэхүүний борлуулалтын орлогоос генетик нөөц эзэмшигчид дараах байдлаар мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр үр шим хүртээнэ:

18.3.1. мөнгөн үр шим нь бүтээгдэхүүний борлуулалтын орлогын үнийн дүнгийн 1.0-ээс доошгүй хувь байх бөгөөд үүнийг улсын төсөвт төлнө.

18.3.2. мөнгөн бус үр шим нь бүтээгдэхүүний борлуулалтын орлогын үнийн дүнгийн 2.0-оос доошгүй хувьтай тэнцэх хэмжээтэй байх бөгөөд энэ хуулийн 17.4-т заасан хэлбэрээр хүртээнэ.

18.4. Генетик нөөцтэй холбоотой төрийн эзэмшлийн уламжлалт мэдлэгийг ашиглан гаргаж авсан бүтээгдэхүүний борлуулалтын орлогын үнийн дүнгийн 1.0-ээс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний үр шимийг тусгай зөвшөөрөл эзэмшигч нь улсын төсөвт төлнө.

18.5. Энэ хуулийн 18.3.1, 18.4-т заасан генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласнаас үүдэх мөнгөн үр шимийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд төлнө.

18.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хувийн эсхүл хамтын эзэмшлийн генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглан гаргаж авсан бүтээгдэхүүний борлуулалтын орлогоос эзэмшигчтэй байгуулсан үр шимийн гэрээнд заасан төрөл, хэмжээгээр мөнгөн болон мөнгөн бус үр шимийг хүртээнэ.

18.7. Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласны үр шимээс улсын төсөвт орсон орлогын 50-аас доошгүй хувийг Байгаль орчин, уур амьсгалын санд төвлөрүүлэн, генетик нөөцийг тогтоох, судлах, хамгаалах, нөхөн сэргээх, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, генетик нөөцийн үндэсний санг хөгжүүлэхэд зарцуулна.

18.8. Генетик нөөц нь хязгаарлагдмал тархац нөөцтэй нутаг дэвсгэрээс гарал үүсэлтэй тохиолдолд түүнээс үүдэх үр шимийн төлбөрийн 35-аас доошгүй хувийг тухайн нутаг дэвсгэрийн генетик нөөцийг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулна.

18.9. Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэг ашиглаж гаргасан бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг тооцохдоо дотоодын болон олон улсын зах зээлд борлуулсан тухайн бүтээгдэхүүний эсхүл адил төстэй бүтээгдэхүүний зах зээлийн жишиг үнэ, тоо хэмжээг баримтлах бөгөөд тодорхойлох боломжгүй тохиолдолд зөвшөөрөл эзэмшигчийн мэдүүлсэн борлуулалтын орлогыг үндэслэнэ.

18.10.Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг арилжааны бус судалгааны зорилгоор ашиглах тохиолдолд мөнгөн хэлбэрээр үр шим хүртээхгүй байж болно.

18.11.Инновацийн тухай хуульд заасан гарааны компани нь биотехнологийн аргаар хөгжүүлэлт хийж инновацийн бүтээгдэхүүн шинээр үйлдвэрлэсэн бол тухайн бүтээгдэхүүний борлуулалтын орлогоос мөнгөн үр шимийн төлбөрийг гурван жилийн хугацаанд төлөхгүй байж болно.

## **ТАВДУГААР БҮЛЭГ**

### **БУСАД ЗҮЙЛ**

#### **19 дугаар зүйл. Мэдээ, тайлан гаргах**

19.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах мэдээ, тайланг дор дурдсан хугацаанд гаргаж, төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ:

19.1.1.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглаж байгаа талаарх ажлын жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор;

19.1.2.мэдээллийн нэгдсэн санд орох мэдээллийг тухай бүр;

19.1.3.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг дотооддоо ашиглах бол зардлын төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор, гадаадад ашиглах бол холбогдох явцын тайланг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор;

19.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд борлуулсан генетик нөөцөөс гаралтай бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын төсөвт төлсөн төлбөрийн хэмжээг дараа оны 1 дүгээр улиралд багтаан төрийн захиргааны төв байгууллагад мэдээлнэ.

#### **20 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

20.1.Энэ хуулийг зөрчсөн хувь хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

20.2.Энэ хуулийг зөрчсөн төрийн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

#### **21.Амьтан, ургамал, бичил биетний генетик нөөцийг улсын хилээр нэвтрүүлэхэд тавих мэргэжлийн хяналт**

21.1.Амьтан, ургамал, бичил биетний генетик нөөцийг улсын хилээр нэвтрүүлэхэд төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлийг үндэслэн холбогдох мэргэжлийн хяналтын алба, улсын байцаагч хяналт тавина.

21.2.Мэргэжлийн хяналтын алба, улсын байцаагч нь Төрийн хяналт, шалгалтын тухай хуулиар тогтоосон эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

#### **22 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

22.1.Энэ хуулийг 2020 оны 7 дугаар сарын 1-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

### **ГАРЫН ҮСЭГ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2019 оны .. дугаар  
сарын ..-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

**1/7 дугаар зүйлийн 7.3.18 дахь заалт:**

“7.3.18.Генетик нөөцийн тухай хуулийн 18.3-18.4-т заасан генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласны үр шимийн төлбөр.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Генетик нөөцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны .. дугаар  
сарын ..-ны өдөр

Улаанбаатар  
хот

**АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсгийн “Хувиргасан амьд организмын тухай” гэсний дараа “, Генетик нөөцийн тухай” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Генетик нөөцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны .. дугаар  
сарын ..-ны өдөр

Улаанбаатар  
хот

**УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах заалт тус тус нэмсүгэй:

**1/5 дугаар зүйлийн 5.1.46 дахь заалт:**

“5.1.46.Генетик нөөцийн тухай хуулийн 7.1.3, 7.4.2, 16.3-т заасан тусгай зөвшөөрөл, гарал үүслийн тодорхойлолт, хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох.”

**2/21 дүгээр зүйлийн 21.1.36 дахь заалт:**

“21.1.36.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг судалгааны зорилгоор ашиглах нэг удаагийн зөвшөөрөл олгоход 20,000-100,000 төгрөг, арилжааны зорилгоор ашиглах нэг удаагийн зөвшөөрөл олгоход 500,000-2,000,000 төгрөг, гарал үүслийн тодорхойлолт олгоход 25,000 төгрөг, бичил биетнийг гадаад улсад гаргах нэг удаагийн зөвшөөрөл олгоход 20,000-500,000 төгрөг.

**2 дугаар зүйл.** Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дэх хэсгийн “21.1.30” гэснийг “21.1.36” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Генетик нөөцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2019 оны .. дугаар  
сарын ..-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

**1/23 дугаар зүйлийн 23.4.13 дахь заалт:**

“23.4.13.Генетик нөөцийн тухай хуулийн 18.3-18.4-т заасан генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласны үр шимийн төлбөр.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Генетик нөөцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны .. дугаар  
сарын ..-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Зөрчлийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах зүйлийг нэмсүгэй:

**1/7.18 дугаар зүйл. Генетик нөөцийн тухай хууль зөрчих:****“7.18 дугаар зүйл. Генетик нөөцийн тухай хууль зөрчих:****1. Хуульд заасныг зөрчиж,**

1.1. Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг тусгай зөвшөөрөлгүйгээр ашигласан;

1.2. Генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг гадаадын иргэн, хуулийн этгээдэд дамжуулсан, худалдсан бол зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хурааж, хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг найман мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эсхүл долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулна.

**2. Хуульд заасан:**

2.1. Генетик нөөцийг хилээр нэвтрүүлэхдээ зөвшөөрөл авах;

2.2. Генетик нөөцийг хилээр нэвтрүүлэхдээ генетик нөөцийн биет эсхүл сорьцын ижил хувийг генетик нөөцийн үндэсний санд хадгалуулах үүргээ биелүүлээгүй бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг найман мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

**3. Хуульд заасан:**

3.1. Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглаж байгаа талаарх ажлын тайлан, мэдээгээ хугацаанд нь үнэн зөв гаргаж өгөх;

3.2. Генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн үнэ цэнэ, үр шимийн талаар эзэмшигчид тайлбарлан таниулах;

3.3. Генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг эзэмшигчийг тодорхойлох, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах урьдчилсан зөвшөөрөл авах журмыг сахин мөрдөх;

3.4. Үр шимийн гэрээний хуулбар хувийг төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн цахим бүртгэлд бүртгүүлэх үүргээ биелүүлээгүй бол хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



4.Хуульд заасныг зөрчиж,

4.1. Генетик нөөц ашигласны төлбөр, мөнгөн болон мөнгөн бус үр шимийг төлөөгүй;

4.2. Генетик нөөцийг ашиглан гаргаж авсан бүтээгдэхүүний борлуулалтын орлогоо мэдүүлээгүй, тоо хэмжээг нуун дарагдуулсан эсхүл худал мэдүүлсэн;

4.3. Үр шимийн гэрээнд заасныг зөрчсөн бол хуулийн этгээдийг арван таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Генетик нөөцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны .. дугаар  
сарын ..-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХОВОРДСОН АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ  
ЭД ЗҮЙЛИЙН ГАДААД ХУДАЛДААГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

**1/9 дүгээр зүйлийн 9.1.8 дахь заалт:**

“9.1.8.тухайн ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг Генетик нөөцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлсэн эсэх.”

**2 дугаар зүйл.** Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Гаалийн тухай” гэсний дараа “, Генетик нөөцийн тухай” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Генетик нөөцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны .. дугаар  
сарын ..-ны өдөр

Улаанбаатар  
хот

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Байгаль орчныг хамгаалах тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

**1/35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 35.1.23 дахь заалт:**

“35.1.23.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан.”

**2 дугаар зүйл.** Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.8 дахь хэсгийн "13-18-д" гэснийг "13-18, 23-т" гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Генетик нөөцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны .. дугаар  
сарын ..-ны өдөр

Улаанбаатар  
хот

**БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Байгалийн ургамлын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

**1/11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг:**

“11.3.Ургамлыг судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөл авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага судалгаа, шинжилгээний тайлангаа Генетик нөөцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэх үүрэгтэй.

**2/19 дүгээр зүйлийн 19.7 дахь хэсэг:**

“19.7.Генетик нөөцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх.”

**2 дугаар зүйл.**Байгалийн ургамлын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “хамгаалах тухай” гэсний дараа “, Генетик нөөцийн тухай”, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “зөвшөөрлийн” гэсний дараа “энэ хуулийн 7.4 дэх хэсэгт нийцүүлэн” гэж, 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “бэлтгэх” гэсний дараа “, гадаад улсад гаргах” гэж, 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийн “булцууг” гэснийг “булцуу, үндэс болон үрийг” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Байгалийн ургамлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийг дор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

**1/13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг:**

“13.2.Эм бэлтгэн найруулах ажил, үйлчилгээ эрхэлдэг дотоодын аж ахуйн нэгж, байгууллага ховор болон элбэг ургамлыг эмийн үйлдвэрлэлийн зориулалтаар тарималжуулан ашиглаж болно.”

**2/11 дүгээр зүйлийн 15.5 дахь хэсэг:**

“15.5.Тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч ургамал ашиглах эрхийн бичгийг үндэслэн ургамлыг түүж бэлтгэх газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад зааж өгөх бөгөөд холбогдох эрхийн бичгийн мэдээллийг Генетик нөөцийн тухай

хуулийн 9 дүгээр зүйлд заасан генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэх үүрэгтэй."

**3/17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг:**

"17.1.Ургамал, ургамлын уусмал ханд, хандмал, ялгамлыг гадаад улсад гаргах зөвшөөрлийг Генетик нөөцийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан журмын дагуу төрийн захиргааны төв байгууллага олгоно.

**4 дүгээр зүйл.**Байгалийн ургамлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5 дахь хэсгийг хассугай.

**5 дугаар зүйл.**Энэ хуулийг Генетик нөөцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны .. дугаар  
сарын ..-ны өдөр

Улаанбаатар  
хот

**АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Амьтны тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

**1/25 дугаар зүйлийн 25.6 дахь хэсэг:**

"25.6.Иргэн, хуулийн этгээд энэ хуулийн 25.1, 29.1-д заасан тусгай зөвшөөрөл авахын өмнө Генетик нөөцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлсэн байна."

**2/36 дугаар зүйлийн 36.6 дахь хэсэг:**

"36.6.Энэ хуулийн 36.1-36.2-т заасны дагуу амьтныг амьдаар нь болон амьтны гаралтай түүхий эд, сорьц дээжийг гадаад улсад гаргахдаа Генетик нөөцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ."

**2 дугаар зүйл.**Амьтны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн "хамгаалах тухай" гэсний дараа "Генетик нөөцийн тухай" гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Амьтны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсгийг дор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

**1/20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг:**

20.3.Иргэн, хуулийн этгээдийн амьтны цуглуулгыг гадаадад гаргах зөвшөөрлийг Генетик нөөцийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан журмыг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний дагуу олгоно.

**3/36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэг:**

36.2.Энэ хуулийн 36.1-д заасан амьтнаас бусад амьтныг амьдаар нь, мөн амьтны гаралтай түүхий эд, судалгааны ажлын сорьц дээжийг гадаад улсад гаргах зөвшөөрлийг Генетик нөөцийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан журмын дагуу төрийн захиргааны төв байгууллага олгоно.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Генетик нөөцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны .. дугаар  
сарын ..-ны өдөр

Улаанбаатар  
хот

**АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ  
УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ҮЕИЙН ХОРИО ЦЭЭРИЙН ХЯНАЛТ,  
ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

**1/11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалт:**

"11.1.3.Генетик нөөцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлсэн байх."

**2 дугаар зүйл.**Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн "хамгаалах тухай" гэсний дараа "Генетик нөөцийн тухай" гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Генетик нөөцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны .. дугаар  
сарын ..-ны өдөр

Улаанбаатар  
хот

**МАЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Малын генетик нөөцийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “шалгалтын тухай” гэсний дараа “, Генетик нөөцийн тухай” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Генетик нөөцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны .. дугаар  
сарын ..-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

**1/12 дугаар зүйлийн 12.1.8 дахь заалт:**

“12.1.8.Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласны төлбөрийн орлого;”

**2/12 дугаар зүйлийн 12.2.13 дахь заалт:**

“12.2.13.генетик нөөцийг тогтоох, судлах, хамгаалах, нөхөн сэргээх, мэдээллийн нэгдсэн сан, генетик нөөцийн үндэсний сан бүрдүүлэхэд зарцуулна”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Генетик нөөцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны .. дугаар  
сарын ..-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Эрүүгийн хуульд дор дурдсан агуулгатай дараах зүйлийг нэмсүгэй:

**1/24.10 дугаар зүйл. Генетик нөөц, түүнтэй холбоотой мэдлэгийг хууль бусаар ашиглах:**

1. Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг тусгай зөвшөөрөлгүйгээр ашиглаж үлэмж хэмжээний хохирол учруулсан бол арван таван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

3. Генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг гадаадын иргэн, хуулийн этгээдэд дамжуулан худалдаж үлэмж хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хурааж, хүнийг арван мянган нэгжээс гучин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Генетик нөөцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны .. дугаар  
сарын ..-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХУВИРГАСАН АМЬД ОРГАНИЗМЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Хувиргасан амьд организмын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

**1/9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсэг:**

“9.6.Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглан хувиргасан амьд организмыг гарган авах, ашиглах тохиолдолд Генетик нөөцийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу төлбөр төлнө.”

**2 дугаар зүйл.** Хувиргасан амьд организмын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Технологи дамжуулах тухай хууль,” гэсний дараа “, Генетик нөөцийн тухай” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Генетик нөөцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.